



ЭРЭЭНЦАВ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ

2023 оны 03 дугаар
сарын 09-ний өдөр

Улаанбаатар
хот

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Эрээнцав ХК-ийн нийт Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2023.03.09-ний өдрийн 16:00 цагт Улаанбаатар хот, БЗД-ийн 6-р хороо, 75/1-10 тоот байранд хуралдав.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ц.Лхагвадорж хурлыг нээж, хуралд компанийн нийт хувьцааны **72.32%** буюу 72,122ш хувьцааны эзэмшигчид оролцож байгааг мэдэгдэж, ирцийг танилцуулав. Үүнд:

1. Сийс гэйт ХХК-г төлөөлөн Гүйцэтгэх захирал Л.Ням: 30,000ш хувьцаа, 30.08% ;
 2. Агро кор-Эл ХХК-г төлөөлөн Гүйцэтгэх захирал Д.Эрдэнэзаяа: 30,000ш хувьцаа, 30.08% ;
 3. Иргэн З.Мөнхбат: 12,122ш хувьцаа, 12.16% ;
- нар оролцов.

Хувьцаа эзэмшигчдийн хурал /ХЭХ/-ын бүртгэлийн өдөр болох 2023.02.15-ны өдрөөр тасалбар болгож хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийг бүртгэсэн бөгөөд Сийс гэйт ХХК, Агро кор-Эл ХХК, иргэн З.Мөнхбат нар хуралд оролцохоор бүртгүүлсэн болохыг Компанийн тухай хуулийн 64-р зүйлийн 64.1-т заасны дагуу танилцууллаа.

Түүнчлэн компанийн тухай хуулийн 94-р зүйлийн 94.2, Эрээнцав ХК-ийн дүрэм, Эрээнцав ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах журмын 6.7, Аудитын Бодлогын баримт бичгийн 1.2, 9.1, Компанийн засаглалын кодексийн тайлангийн 4.2-р заалтууд, Аудитын хорооны 2023.03.07-ны өдрийн АХ-02/2023 тоот тогтоолыг тус тус үндэслэн хөндлөнгийн аудитор Г.Зинамидэр ХЭХ-д оролцож байгааг мэдээллээ.

Компанийн тухай хуулийн 69-р зүйлийн 69.1-рт нийт саналын эрх бүхий хувьцааны 50-аас дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид хуралд оролцсоноор тухайн хурал хүчин төгөлдөр болно гэж заасны дагуу хурлын ирц бүрдсэн тул ТУЗ-н дарга Ц.Лхагвадорж хурлыг үргэлжлүүлж, дэгийн дагуу Хурлын дарга, Тооллогын комиссын дарга, гишүүдийг сонгож, батлахыг хувьцаа эзэмшигчдээс хүслээ.

ТУЗ-ийн 2023.01.25-ны өдрийн ТУЗ-11/2023 тоот тогтоолд заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлын даргаар Ц.Лхагвадоржийг, Тооллогын комиссын даргаар Л.Давааг, гишүүдэд Г.Одгэрэл, М.Бат нарыг сонгохыг хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчид 100% дэмжиж, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 1-р тогтоолыг гаргахаар тогтлоо.

Хурал даргалагч Ц.Лхагвадорж ТУЗ-ийн 2023.01.25-ны өдрийн ТУЗ-11/2023 тоот тогтоолд заасны дагуу ХЭХ-аар хэлэлцүүлэх асуудлуудыг танилцууллаа. Үүнд:

1. Компанийн 2022 оны Үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Компанийн 2022 оны Санхүүгийн тайлангийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
3. ТУЗ-ийн гишүүдийг сонгох, зарим гишүүний бүрэн эрхийг дуусгавар болгох;
4. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох;
5. Бусад;

Хурлаар хэлэлцэх асуудлуудыг хувьцаа эзэмшигчид 100% дэмжиж баталлаа.

Хэлэлцсэн нь:

1. Компанийн тухай хуулийн 76-р зүйлийн 76.11-д ТУЗ нь компанийн жилийн үйл ажиллагааны тайлангийн талаар дүгнэлт гаргаж, ХЭХ-д танилцуулж, батлуулна гэж заасны дагуу ТУЗ-н 2023.01.25-ны өдрийн ТУЗ-07/2023 тоот тогтоолоор баталсан дүгнэлтийг танилцууллаа.
2. Компанийн тухай хуулийн 76-р зүйлийн 76.11-д ТУЗ нь компанийн жилийн санхүүгийн тайлангийн талаар дүгнэлт гаргаж, ХЭХ-д танилцуулж, батлуулна гэж заасны дагуу ТУЗ-н 2023.03.09-ны өдрийн ТУЗ-14/2023 тоот тогтоолоор баталсан дүгнэлтийг танилцууллаа.
3. Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.7-д Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ТУЗ-н гишүүдийг сонгох, бүрэн эрхийг нь хугацаанаас нь өмнө дуусгавар болгох бүрэн эрхтэй гэж заасан ба 2022 онд Эрээнцав хувьцаат компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид өөрчлөгдөж, менежментийн шинэ баг ажиллах болсонтой холбогдуулан Б.Энхамгалан, Г.Отгонгэрэл, О.Тамир, М.Жалавдорж нарыг ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлж, бүрэн эрхийг дуусгавар болгох саналыг танилцууллаа.

Түүнчлэн Мижиддоржийн Бат, Дашпунцагийн Эрдэнэзаяа, Зандаръяагийн Мөнхбат нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнээр, Нэргүйн Баярсайханыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгох саналыг ТУЗ-ийн зүгээс оруулж буй талаар мэдэгдээд нэр дэвшигч бүрийн анкет, мэдлэг боловсрол, ажлын туршлагын талаар танилцууллаа. ТУЗ-н хараат бус гишүүнд дэвшиж буй Н.Баярсайхан нь Компанийн тухай хуулийн 79-р зүйлд заасан хараат бус гишүүнд тавигдах шалгуур /хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшдэггүй, нэгдмэл сонирхолтой этгээд биш, төрийн алба хашдаггүй, мэдлэг чадвар өндөр/-ыг хангаж байгаа бөгөөд компанийн Нэр дэвшүүлэх хорооны 2023.03.07-ны өдрийн НДХ-01/2023 тоот тогтоолын дагуу дэвшүүлээ.

2022.02.08-нд компанийн цахим шууданд иргэн Батсуурийн Ганбаяр өөрийгөө компанийн хараат бус гишүүнд нэр дэвшүүлэх санал болон холбогдох материалыг ирүүлснийг судалж үзсэн талаар танилцууллаа.

4. Компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.1.13-т ХЭХ нь ТУЗ-н гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг тогтоох бүрэн эрхтэй гэж заасны дагуу цалин урамшууллын хэмжээг хувьцаа эзэмшигчдийн санал хураалтаар шийдвэрлэх талаар танилцууллаа.

Хэлэлцэх асуудлуудыг танилцуулж дууссаны дараа хувьцаа эзэмшигчид зарим нэг зүйлийг тодруулж, хэлэлцээд ТУЗ-н 2023.03.09-ны өдрийн ТУЗ-14/2023 тоот тогтоолоор батлагдсан саналын хуудсаар саналаа өгч, нийт асуудлуудыг шийдвэрлэхээр тогтлоо.

Санал хураалт:

Хувьцаа эзэмшигч бүрт хэлэлцсэн бүх асуудлаар саналаа өгөх 8 ш хуудсыг Тооллогын комиссоос тараан өгч санал авсан. Үүнд:

1. 2022 оны Үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтийг Зөвшөөрөх, Татгалзах, Түтгэлзэх;
2. 2022 оны Санхүүгийн тайлангийн дүгнэлтийг Зөвшөөрөх, Татгалзах, Түтгэлзэх;
3. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч тус бүрийг Зөвшөөрөх, Татгалзах, Түтгэлзэх;
4. ТУЗ-ийн гишүүдийг чөлөөлөхийг Зөвшөөрөх, Татгалзах, Түтгэлзэх;
5. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг сонгох;

Хувьцаа эзэмшигчид саналаа тэмдэглэж албажуулсны дараа Тооллогын комис саналын хуудсуудыг хүлээн авч, нийт саналыг кумулятив аргаар тоолж, дүнг Хувьцаа эзэмшигчидэд танилцуулав. Үүнд:

1. 2022 оны Үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтийг батлах: **100% Зөвшөөрсөн;**
2. 2022 оны Санхүүгийн тайлангийн дүгнэлтийг батлах: **100% Зөвшөөрсөн;**
3. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч М.Батыг сонгох: **100% Зөвшөөрсөн;**
4. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч Д.Эрдэнэзаяаг сонгох: **100% Зөвшөөрсөн;**
5. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч З.Мөнхбатыг сонгох: **100% Зөвшөөрсөн;**
6. ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигч Н.Баярсайханыг сонгох: **100% Зөвшөөрсөн;**
7. ТУЗ-ийн зарим гишүүдийг чөлөөлөх: **100% Зөвшөөрсөн;**
8. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээ: **600,000 төг - 100% Зөвшөөрсөн;**

Тооллогын комис санал хураалтын дүнг нэгтгэж, 2023.03.09-ний өдрийн ТК-01/2023 тоот “Санал хураалтын дүнгийн тухай” тогтоолыг гарган ХЭХ- танилцуулав.

Шийдвэрлэсэн нь:

Санал хураалтын дүн болон Тооллогын комисын тогтоолыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлаас дараах шийдвэрийг гаргав. Үүнд:

1. ХЭХ-ын Тооллогын комисын ТК-01/2023 тоот тогтоолыг хүлээж авах;
2. 2022 оны Үйл ажиллагааны тайлангийн дүгнэлтийг батлах;
3. 2022 оны Санхүүгийн тайлангийн дүгнэлтийг батлах;
4. М.Батыг ТУЗ-н гишүүнээр сонгох;
4. Д.Эрдэнэзаяаг ТУЗ-н гишүүнээр сонгох;
5. З.Мөнхбатыг ТУЗ-н гишүүнээр сонгох;
6. Н.Баярсайханыг ТУЗ-н хараат бус гишүүнээр сонгох;
7. Б.Энхамгалан, Г.Отгонгэрэл, О.Тамир, М.Жалавдорж нарыг ТУЗ-ийн гишүүнээс чөлөөлөх;
8. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшууллын хэмжээг 600,000 төгрөгөөр тогтоох;
9. ХЭХ-аар хэлэлцэж, шийдсэн асуудал бүрээр Тогтоол гаргах;

зэрэг болно.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 17:55 цагт дуусав.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН
ХУРЛЫН ДАРГА:

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД:

Ц.ЛХАГВАДОРЖ

Л.НЯМ /Сийс гайт ХХК/

Д.ЭРДЭНЭЗАЯА /Агро кор-эл ХХК/

З.МӨНХБАТ

